



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



---

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ - 2020 II

---



Улаанбаатар хот  
2020 он

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжиж буй болон хөгжингүй зах зээлтэй орнуудын санхүүгийн зах зээлд макро эдийн засаг болон мөнгө, сангийн бодлогын нөлөөлөх хувьсагч үзүүлэлтүүдийн талаарх судалгааг хийж, холбогдох бодлогын зөвлөмжүүдийг тогтмол олон нийгэд хүргэх ажлыг хийж гүйцэтгэдэг бөгөөд дээрх байгууллагуудаас үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, хувьцааны төвлөрөл, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хувьцааны индекс гэсэн үндсэн хэсгүүдэд хуваан авч үздэг.

### 1.1. Зах зээлийн үнэлгээ

Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2020 оны хагас жилийн байдлаар 2.5 их наяд төгрөг буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч сүүлийн 18 сарын 3ЗҮ-ний тренд өссөн байдалтай байна.

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Нийт зах зээлийн үнэлгээний 89.56 хувийг хөрөнгийн биржүүдэд бүртгэлтэй нийт 200 компанийн ердөө 30 компани бүрдүүлж байна. Үүнд:

Хүснэгт 1. 3ЗҮ хамгийн өндөр 30 компани

д/д	Компанийн нэрс	Зах зээлийн үнэлгээ	д/д	Компанийн нэрс	Зах зээлийн үнэлгээ
1	АПУ	584,235,672,597.00	16	БОДЬ ДААТГАЛ	26,325,216,852.66
2	ТАВАНТОЛГОЙ	292,291,860,000.00	17	ШИВЭЭ ОВОО	25,912,284,031.00
3	МИК ХОЛДИНГ	269,014,066,800.00	18	МАНДАЛДААТГАЛ	25,034,494,160.00
4	ИНВЕСКОР ББСБ	180,323,985,852.00	19	ЛЭНДМН ББСБ ХК	24,448,000,000.00
5	ГОВЬ	152,121,937,500.00	20	ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ	23,907,214,800.00
6	МОНГОЛ ДААТГАЛ	96,198,511,500.00	21	БАГАНУУР	19,925,642,000.00
7	СҮҮ	64,283,280,000.00	22	АРД КРЕДИТ ББСБ ХК	19,611,200,000.00
8	МОНГОЛ ШУУДАН ХК	63,735,272,320.00	23	АРД ДААТГАЛ ХК	17,612,500,000.00
9	УБ-БҮК	52,224,357,500.00	24	ТАХЬ-КО	17,254,753,500.00
10	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	52,009,537,540.00	25	БИ ДИ СЕК	14,637,000,000.00
11	АРД САНХҮҮГИЙН	37,169,927,637.00	26	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	14,384,210,000.00

	НЭГДЭЛ				
12	ГУТАЛ	32,017,569,520.00	27	ШАРЫН ГОЛ	13,831,529,120.00
13	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	28,053,839,034.50	28	БЭРХ УУЛ	13,343,456,000.00
14	ТҮМЭНШУВУУТ	26,878,000,000.00	29	ДАРХАННЭХИЙ	13,265,748,000.00
15	МОНОС ХҮНС	26,575,277,820.00	30	АТАР-ӨРГӨӨ	12,973,132,000.00

### 1.2. Хөрвөх чадвар


Тайланг хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар 2.4 пунктээр буурч 0.9 хувьд хүрсэн бөгөөд уг үзүүлэлт буурахад хувьцааны арилжааны хэмжээ 59.0 тэрбум төгрөгөөр буюу 71.5 хувиар буурсан нь нөлөөлжээ. Олон улсын хөрвөх чадварын тухайд гэвэл 2019 оны жилийн эцсээрх нийт 70 улс орны үзүүлэлтийн дундаж үзүүлэлт 26.2 хувь<sup>1</sup> байна. Энэхүү үзүүлэлт Монгол Улсад маш бага түвшинд байгаа нь голчлон хувьцааны төвлөрөлтэй холбоотой байдаг.

Тухайлбал, зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 10 ХК-ийн төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй /5-аас дээш хувь эзэмшигч/ буюу нийт хувьцааны 90.1 хувийг нийт хувьцаа эзэмшигчдийн ердөө 0.1 хувь нь эзэмшиж байна.

### 1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

Монголын хөрөнгийн бирж дээр ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. Зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 19511.49 нэгж, доод үзүүлэлт 15914.85 нэгж, дундаж үзүүлэлт 17545.91 нэгж байна. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4576.27 нэгжээр буюу 22.02 хувиар буурч, 16208.94 нэгж болсон байна.

Зураг 2. ТОП-20 индекс




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

ТОП 20 индекст багтаж буй компаниудыг салбараар нь ангилж үзвэл 40 хувийг банк санхүү, 35 хувийг аж үйлдвэр, 15 хувийг уул уурхай, 5 хувийг харилцаа холбоо, үлдсэн 5 хувийг худалдаа үйлчилгээний салбарууд тус тус эзэлж байна.

<sup>1</sup> [https://www.theglobaleconomy.com/rankings/stock\\_market\\_turnover\\_ratio/](https://www.theglobaleconomy.com/rankings/stock_market_turnover_ratio/)


Мөн Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьд тооцон гаргаж буй MSE-A болон MSE-B индексүүд өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөн адил буурсан үзүүлэлттэй байна. MSE-A индекс өмнөх оны мөн үеэс 1,680.6 нэгжээр буюу 17.2 хувиар буурсан бол MSE-B индекс өмнөх оны мөн үеэс 635.9 нэгжээр буюу 7.8 хувиар буурсан.

*Зураг 3. MSE-A индекс*



*Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК*

*Зураг 3. MSE-B индекс*



*Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК*

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

### 2.1. Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт тал

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хөрөнгийн бирж дээр хувьцаа, компанийн бонд, ЗГҮЦ гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдаж байна. 2020 оны 2 дугаар улиралд нийт 29.1 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 67.8 хувиар буурсан. Нийт арилжааны 2 хувийг ЗГҮЦ, 17.2 хувийг компанийн бонд, 80.8 хувийг хувьцаа тус тус эзэлж байна.

Үнэт цаасны арилжаа 67.8 хувиар буурсанд хувьцааны арилжаа 71.5 хувь, ЗГҮЦ-ны арилжаа 92.6 хувиар тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Харин хөдөө аж ахуйн бирж дээр тайлант хугацаанд зөвхөн 4 төрлийн нийт 162.1 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 361 тэрбум төгрөгөөр буюу 69.0 хувиар буурсан байна.

#### 2.1.1. Хувьцааны арилжаа

2020 оны 2 дугаар улиралд нийт хувьцааны арилжаа 23.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71.5 хувиар буурч, 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 52.7 хувиар буурчээ.

Хувьцааны арилжаа буурсан нь анхдагч зах зээлийн арилжаа 87 хувиар, хоёрдогч зах зээлийн арилжаа 55 хувиар буурсантай холбоотой байна.

Анхдагч зах зээлийн арилжааны хувьд 2019 оны мөн үед “Түмэн шувуут”, “Ард Кредит ББСБ”, “Монос хүнс”, “Инвескор ББСБ” компаниуд IPO хийж, нийт 42.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж байсан бол энэ онд “Бодь даатгал” компани IPO хийж нийт 5.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

Харин хоёрдогч зах зээлийн арилжааны хэмжээ 2020 оны хагас жилээр 55 хувиар буурсан байгаад дэлхий даяар шинэ коронавирусын халдвар гарсан нь голчлон нөлөөлсөн байх магадлалтай байна.

Хувьцааны арилжааг хэмжээгээр харж үзвэл Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй нийт 199 компанийн ердөө 20 компанийн хувьцаа идэвхтэй арилжаалагддаг бөгөөд нийт арилжааны үнийн дүнгийн 92.2 хувийг бүрдүүлж байна.

#### Хүснэгт 2. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 20 компани

ҮНЭТ ЦААС	ШИРХЭГ	ЭРЭМБЭ	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН
ЛЭНДМНБЛЭНДМНББСБ ХК	27,793,568	1	МОНГОЛ ШУУДАН ХК	3,323,694,248
МОНОС ХҮНС	17,241,677	2	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	2,198,105,994
ХАЙБИ ОЙЛ	16,632,270	3	МОНОС ХҮНС	1,380,593,949
СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	13,637,866	4	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	1,325,407,688
МАНДАЛДААТГАЛ	9,867,488	5	АПУ	1,261,883,545
АРД КРЕДИТ ББСБ ХК	8,279,538	6	ЛЭНДМНББСБ ХК	978,133,926.30
МОНГОЛ ШУУДАН ХК	5,357,959	7	ХАЙБИ ОЙЛ	770,242,010.20
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	4,417,238	8	Инвескор ББСБ	661,021,505
ГОВЬ	2,195,830	9	АРД КРЕДИТ ББСБ ХК	635,074,434.80
АПУ	2,164,163	10	АДУУН ЧУЛУУН	625,804,036
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,427,149	11	МАХИМПЕКС	605,438,711

ТҮМЭНШУВУУТ	1,261,738	12	АРДДААТГАЛХК	584,852,774.30
СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП	1,048,303	13	СТАНДАРТ АГРИКАЛЧЕРГРУПП	484,180,620.50
АРДДААТГАЛХК	832,163	14	МАНДАЛДААТГАЛ	471,131,596.80
ХАРХОРУМ ПРОПЕРТИЙС	818,829	15	ГОВЬ	465,466,975
Бодь ДаатгалХК	610,534	16	ТАВАНТОЛГОЙ	342,477,714
АДУУНЧУЛУУН	592,691	17	ЖУУЛЧИН ДЮТИФРИЙ	228,987,880
МОНГОЛБАЗАЛТХК	550,397	18	ТҮМЭНШУВУУТ	186,000,637.80
АЙТҮҮЛС	418,501	19	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	154,155,047.30
НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ БСБХК	372,704	20	АРИГГАЛ	133,781,131
<b>НИЙТ</b>	<b>115,520,606</b>		<b>НИЙТ</b>	<b>16,816,434,423</b>
<b>НИЙТЭД ЭЗЛЭХ ХУВЬ</b>	<b>97.90%</b>		<b>НИЙТЭД ЭЗЛЭХ ХУВЬ</b>	<b>92.20%</b>

### 2.1.1.1. Багцын арилжаа

Тайлант хугацаанд багцын арилжаагаар “Лэнд МН” ХК-ийн 5.3 сая ширхэг хувьцааг 250.0 сая төгрөгөөр, “Хай Би Ойл” ХК-ийн 16.6 сая ширхэг хувьцааг 769.0 сая төгрөгөөр, “Даваанбулаг” ХК-ийн 244.2 мянган ширхэг хувьцааг 48.0 сая төгрөгөөр, “Дорнод авто зам” ХК-ийн 38.8 мянган ширхэг хувьцааг 100.1 сая төгрөгөөр, “Монгол шуудан” ХК-ийн 1.0 сая ширхэг хувьцааг 600.0 сая төгрөгөөр, “Ард кредит ББСБ” ХК-ийн 3.5 сая ширхэг хувьцааг 287.5 сая төгрөгөөр, “Монос хүнс” ХК-ийн 4.2 сая ширхэг хувьцааг 354.0 сая төгрөгөөр арилжсан байна.

Нийт 3.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 41.7 сая ширхэг хувьцааг багцын арилжаагаар арилжсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 16.3 хувийг эзэлж байна.

### 2.1.2. ЗГҮЦ-ны арилжаа

Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй байна. Харин ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлд 5.8 мянган ширхэг үнэт цаасыг 586.9 сая төгрөгөөр арилжсан байна. 2020 оны 2 дугаар улиралд ЗГҮЦ-ны арилжаа 0.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 92.6 хувиар, 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 98 хувиар тус тус буурчээ.

### 2.1.3. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

Сүүлийн 2 жилийн хугацаанд Монголын хөрөнгийн зах зээл дээр зөвхөн 2 компани /”Минж проперти” ХХК, “ЛэндМН” ХК/ олон нийгэд санал болгон өрийн хэрэгсэл гаргасан.

“Минж проперти” ХХК нь 1 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийн 2018 онд Хороонд бүртгүүлэн хөрөнгө оруулалтаа амжилттай татан, бондын эргэн төлөлтийг хугацаандаа бүрэн төлж дуусаад байгаа бол “Лэндмн ББСБ” ХК-ийн нийгэд санал болгон гаргасан нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 17 хувийн хүүтэй нийт 5.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 50.0 мянган ширхэг өрийн хэрэгслийг амжилттай арилжаалаад байна.

### 2.1.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

ХААБиржээр нийт 162.1 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 361 тэрбум төгрөгөөр буюу 69.0 хувиар буурсан бөгөөд зөвхөн 4 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан байна. Үүнд:

Зураг 4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



### 2.1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор 2013 оноос ипотекийн бага хүүтэйгээр орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн. Өнөөгийн байдлаар “МИК ОССК” ХХК-иас 24 тусгай зориулалтын компани /ТЗК/-ийг үүсгэн байгуулж, нийт 83,674 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт цаасжуулж 4.4 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Хороонд бүртгүүлээд байна.

Монгол Улсад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг үл хөдлөх хөрөнгийн зээлээр баталгаажуулж ирсэн бөгөөд 2020 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 63,775 зээлдэгчийн 2.9 их наяд төгрөгийн баталгаат үнэт цаас байна.

Мөн үүрэн телефоны оператор болох “Жимобайл” ХХК нь 2019 оны 5 дугаар сард хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан нь үл хөдлөх хөрөнгийн зээлээс өөр төрлийн санхүүгийн хэрэгслээр баталгаажсан үнэт цаас гаргасан анхны тохиолдол болсон бөгөөд нийт 7.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас гаргаснаас 2020 оны хагас жилийн байдлаар 4.0 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийн үлдэгдэлтэй байна.

### 2.2. Үнэт цаасны зах зээлийн эрэлт тал

Үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 1,849,136 шинэ данс, 306,927 холболтын данс нээгдсэн байна. Үүнээс 2,291,589 дотоодын иргэн, 2,315 гадаадын иргэн, 2,832 дотоодын аж ахуйн нэгж, 197 гадаад аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

2019 оны мөн үетэй харьцуулахад нийт дансны тоо 29.4 хувиар нэмэгдсэн ба үүнд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг тараах шийдвэр гаргасан нь нөлөөлсөн байна.

#### 2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

2019 оны хагас жилийн эцсийн байдлаар гадаадын ААН, гадаадын иргэдийн хийсэн арилжаа нийт хийгдсэн арилжааны 35 хувийг эзэлж байсан бол 2020 онд 77 хувиар буурч ердөө 8 хувийг эзэлж байна.

Гадаадын ААН	Гадаадын иргэн	Дотоодын ААН	Дотоодын иргэн	НИЙТ
21%	14%	28%	37%	100%
1%	7%	54%	38%	100%

Макро эдийн засгийн өсөлт саарч буйгай холбогдуулан гадаадын хөрөнгө оруулагчдын компанийн хувьцааг худалдан авах сонирхол буурсан, зах зээлд хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл дутмаг, хөрвөх чадварын түвшин доогуур, гадаад валютын эрсдэлээс хамгаалах механизм бүрдээгүй байгаа зэрэг нь гадаадын хөрөнгө оруулагчдын хувь хэмжээ буурахад нөлөөлж байна.

## ХОЁРДУГААРБҮЛЭГ: ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИД

Үнэт цаасны зах зээлд оролцогчдын хувьд 2020 оны хагас жилийн эцсийн байдлаар үнэт цаасны бүртгэлийн чиглэлээр 7, тусгай зөвшөөрлийн чиглэлээр 22, зөвшөөрлийн чиглэлээр 30 асуудлыг тус тус шийдвэрлэсэн. Үүнд:

Үнэт цаасны бүртгэлийн чиглэлээр	Тусгай зөвшөөрлийн чиглэлээр	Зөвшөөрлийн чиглэлээр
<ul style="list-style-type: none"> <li>• Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай - 3</li> <li>• Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх тухай- 1</li> <li>• Хамтын хаалттай сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэх тухай -1</li> <li>• Нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэх тухай-1</li> <li>• Нэмж гаргасан үнэт цаасыг бүртгэх -1</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Тусгай зөвшөөрөл олгох тухай ХОМК -1</li> <li>✓ Тусгай зөвшөөрөл олгох тухай ХААБ -2</li> <li>✓ Тусгай зөвшөөрөл сунгах тухай ХААБ-6</li> <li>✓ “МИК ОССК” ХХК-тай холбоотой шийдвэр -7</li> <li>✓ Арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгох тухай -1</li> <li>✓ Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай -1</li> <li>✓ Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох тухай -2</li> <li>✓ Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай -1</li> <li>✓ НОСК ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай -1</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>○ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай -8</li> <li>○ Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх тухай -3</li> <li>○ Тусгаарлагдсан хувьцааг чөлөөлөх тухай -2</li> <li>○ Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай -2</li> <li>○ Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай - 2</li> <li>○ Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай - 1</li> <li>○ Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилохыг зөвшөөрөх тухай-2</li> <li>○ Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгох тухай-5</li> <li>○ Салбар байгуулахыг зөвшөөрөх тухай -1</li> <li>○ Оноосон нэрийг өөрчлөх -2</li> <li>○ Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай -2</li> </ul>

Ингэснээр 2020 оны хагас жилийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр нийт 133 компани тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа ба Хорооны бүртгэлд нийт 304 ХК бүртгэлтэй байна.

<b>№</b>	<b>Үйл ажиллагааны төрөл</b>	<b>Тоо</b>
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	2
2	Үнэт цаасны тооцооны байгууллага	2
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн байгууллага	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	23
5	Кастодиан	3
6	Үнэт цаасны компани /брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх/	53
7	Хөрөнгө итгэмжлэн удирдах	5
8	Үнэт цаасны итгэмжлэн удирдах	1
9	Хөдөө аж ахуйн бирж	1
10	Хөдөө аж ахуйн брокер	14
11	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч ТЗК	28
<b>Нийт</b>		<b>133</b>
12	Хувьцаат компани	304
<b>Нийт</b>		<b>437</b>

Мөн 2020 оны хагас жилийн эцсийн байдлаар Хороонд бүртгүүлсний үндсэн дээр үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх 33, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 24, аудитын үйлчилгээ үзүүлэх 59 компани байна.

## ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР